



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2023

Судалгааны тайлан

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

Хүүхдийн шударга байдал *Судалгааны тайлан*

Агуулга

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
1.1. Судалгааны зорилго, зорилт	3
1.2. Судалгааны зарчим, арга	3
1.3. Судалгааны хамрах хүрээ	4
1.4. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	4
1.5. Шударга байдлын шалгуур, тооцоолол	4
1.5.1 Үнэлгээний утга	4
1.5.2 Шалгуур	5
1.5.3 Үнэлгээг тооцох арга	5
ХОЁР. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
2.1. Сурагч	7
2.2. Эцэг, эх	8
2.3. Багш, албан хаагч	9
ГУРАВ. СУДАЛГААНЫ ДҮН	10
3.1. Хүүхдийн шударга байдлын түвшин	10
3.2. Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл	14
3.3. Эцэг, эхчүүдийн судалгааны дүн	16
3.4. Багш, албан хаагчдын судалгааны дүн	17
ТАВ. ДҮГНЭЛТ	19
ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	21
ХАВСРАЛТ	22

Зургийн жагсаалт

Зураг 1. Сурагчдын нас, хүйс.....	7
Зураг 2. Сурагчдын анги, хүйс.....	7
Зураг 3. Эцэг эхчүүдийн насны бүлэг	8
Зураг 4. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин.....	8
Зураг 5. Эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	9
Зураг 6. Багш, албан хаагчдын насны бүлэг, хүйс	9
Зураг 7. Багш, албан хаагчдын ажилласан жилээр	9
Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор	10
Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 он, аймгаар	10
Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 он, дүүргээр.....	11
Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр.....	12
Зураг 12. Хүүхдийн шударга байдлын түвшин, өмчийн хэлбэрээр	12

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Судалгааны зорилго, зорилт

Зорилго:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, төлөвшил, мөн хууль сахих болон авлигыг үл тэвчих чадвар, хандлага ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

Зорилт:

1. Хүүхдийн шударга ёсны талаарх ойлголт, мэдээлэл, хандлагыг тодорхойлох;
2. Хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох;
3. Хүүхдийн шударга бус байдалд хандах хандлагыг тодорхойлох;
4. Хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх;
5. Хүүхдэд авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэгийг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх чиг үүргийг хэрхэн оновчтой хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох.
6. Эцэг эх, багш, асран хамгаалагчдын шударга ёсны талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох

1.2. Судалгааны зарчим, арга

Зарчим:

Судалгаа нь аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан, хараат бус байх, шинжлэх ухааны арга зүйг баримталсан байх, үндэслэл бүхий байх, мэдээллийн эх үүсвэр тодорхой байх, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон явууллаа.

Монгол Улсын АТГ-ын төлөөлөл “Транспарэнси интернэшнл” байгууллагын БНСУ-ын салбараас 2008 оны 5 дугаар сард 17 улсын авлигын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаачдыг оролцуулан зохион байгуулсан “Хүүхдийн шударга байдлын судалгааны аргачлал, арга зүйг боловсруулах” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцсон.

Дээрх эрдэм шинжилгээний хурлаас хүүхдийн шударга байдлын түвшнийг хүүхдийн насны онцлогт тохирсон байдлаар хэрхэн тогтоох талаар хэлэлцэж, судалгааны ерөнхий аргачлал, арга зүйг боловсруулж, тус судалгааг өөр өөрсдийн улсад тохирохуйц арга, аргачлалаар зохион байгуулахыг хуралд оролцогч улсуудад уриалсан бөгөөд 2008 онд Монгол Улс, БНСУ, БНЭУ, БНБАУ-д Хүүхдийн шударга байдлын судалгааг явуулж, судалгааны үр дүнг Грек Улсын Афин хотод 2008 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2008 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан Олон Улсын авлигын эсрэг 13 дахь удаагийн бага хуралд танилцуулсан.

Монгол Улсын АТГ-ын даргын 2020 оны 3 сарын 12-ны өдрийн А/23 дугаар тушаалаар дээр дурдсан эрдэм шинжилгээний хурлаас тогтоосон арга аргачлалыг иш үндэс болгон Монгол

Улсын онцлогт нийцсэн Хүүхдийн шударга байдлын судалгааны арга, аргачлал, тус судалгааг зохион байгуулах ажлын удирдамж, судалгааны санал асуулгын загвар төслийг тус тус баталсан бөгөөд тус аргачлалд дурдсанаар судалгааг санал асуулгын аргаар явуулан үр дүнг нь тооцоолсон.

1.3. Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд улсын хэмжээний төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагч, тэдгээрийн эцэг эх, багш, сургуулийн албан хаагч нарыг хамруулсан.



<i>Санал асуулга</i>		
<i>ЕБС-ийн X-XII ангийн сурагчид</i>	<i>ЕБС-ийн X-XII ангийн сурагчдын эцэг, эх</i>	<i>ЕБС-ийн багш, албан хаагч</i>
<i>23 асуулттай</i>	<i>13 асуулттай</i>	<i>11 асуулттай</i>

1.4. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Санал асуулгын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг болон нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1) 10-12 дугаар ангийн сурагчид, 2) багш, албан хаагч, 3) эцэг, эх гэсэн 3 бүлгээс судалгаанд оролцогчийг санамсаргүй байдлаар сонгон авсан бөгөөд санал асуулгын судалгаагаар цугларсан мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулж, үр дүнд үндэслэн судалгааны тайланг боловсруулав.

1.5. Шударга байдлын шалгуур, тооцоолол

1.5.1 Үнэлгээний утга

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг 1-5 хүртэлх оноогоор гаргах бөгөөд үнэлгээ 5 руу дөхөх тусам хүүхдийн шударга байдал өндөр байгааг илэрхийлнэ.



1.5.2 Шалгуур

Хүүхдийн шударга байдлын түвшнийг хүүхдийн ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт, зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт, дүрэм, журам, хууль сахих байдлын дэд үзүүлэлт болон авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтээр тооцно. (*Хүснэгт 1.*)

Хүснэгт 1. Шударга байдлын шалгуур

<i>Шударга байдлын шалгуур</i>	<i>Тодорхойлолт</i>
ХҮҮХДИЙН ЁС ЗҮЙ, ЁС СУРТАХУУНЫ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн ёс зүй, ёс суртахууныг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба уг дэд үзүүлэлт нь хүүхдийн ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛТИЙН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн зөв хүмүүжлийн төлөвшилтийг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба хүүхэд зөв бурууг ялгаж буйг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН ДҮРЭМ, ЖУРАМ, ХУУЛЬ САХИХ БАЙДЛЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн хууль тогтоомж сахин биелүүлэх байдлыг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба хэрхэн хүүхэд өөрийгөө хянаж нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахиж буйг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн насны онцлогт тохирсон асуултаар авлигын тохиолдлыг тэвчих байдлыг тогтоох дэд үзүүлэлт ба хүүхдийн авлигыг үл тэвчих чадварыг илэрхийлнэ.

1.5.3 Үнэлгээг тооцох арга

Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцоходоо асуулгын 12 асуултыг дэд үзүүлэлтийн түвшнийг танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн байдлыг тогтооход чиглэснээр нь ангилан, тухайн асуулт судалгааны асуултад тухайн хүүхэд санал нийлж буй эсэхийг асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлнэ.

Дэд үзүүлэлт	<i>Хүүхдийн ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт</i>
	<i>Хүүхдийн зөв шударга төлөвшилтийн дэд үзүүлэлт</i>
	<i>Хүүхдийн дүрэм, журам, хууль сахих байдлын дэд үзүүлэлт</i>
	<i>Хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт</i>

Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзэх ба хүүхдийн шударга байдлын түвшнийг дараах томъёогоор тооцон гаргана:

Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцон гаргах томъёо (1-7, 9-10, 12 дугаар асуултыг тооцох):

$$\bar{x} = \frac{A_1 \cdot 5 + A_2 \cdot 4 + A_3 \cdot 3 + A_4 \cdot 2 + A_5 \cdot 1}{A_1 + A_2 + A_3 + A_4 + A_5} =$$

\bar{x} – үнэлгээ

A_1 – санал огт нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

A_2 – санал нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

A_3 – эргэлзэж байна гэж хариулсан сурагчдын тоо

A_4 – санал нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

A_5 – санал бүрэн нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцон гаргах томъёо (8 ба 11 дүгээр асуултыг тооцох):

$$\bar{x} = \frac{A_1 \cdot 1 + A_2 \cdot 2 + A_3 \cdot 3 + A_4 \cdot 4 + A_5 \cdot 5}{A_1 + A_2 + A_3 + A_4 + A_5} =$$

\bar{x} – үнэлгээ

A_1 – санал огт нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

A_2 – санал нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

A_3 – эргэлзэж байна гэж хариулсан сурагчдын тоо

A_4 – санал нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

A_5 – санал бүрэн нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо.

Хүүхдийн шударга байдлын түвшний ерөнхий үнэлгээний дунджийг олохдоо арифметикийн жигнэсэн дунджийг ашиглана:

$$\bar{x} = \frac{\sum x_i \cdot f_i}{\sum f_i}$$

\bar{x} – хүүхдийн шударга байдлын түвшний үнэлгээний дундаж

x_i – i асуултын үнэлгээний дундаж оноо

f_i – i дугаар асуултад хариулсан хүүхдийн тоо


ХОЁР. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Сурагч

Монгол улсын 21 аймаг, нийслэлийн төрийн болон хувийн өмчийн сургуулийн 10-12 дугаар ангийн нийт 8693 сурагчдын төлөөлөл хамрагдсан.


Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 59.9 хувь нь эрэгтэй, 40.1 хувь нь эмэгтэй байна. Сурагчдын нас, хүйсийн байдлаар авч үзвэл эрэгтэй сурагчдын 7.6 хувь нь 14 настай, 31.9 хувь нь 15 настай, 34.8 хувь нь 16 настай, 24.2 хувь нь 17 настай, 1.5 хувь нь 18 настай байна. Эмэгтэй сурагчдын 8.1 хувь нь 14 настай, 32.1 хувь нь 15 настай, 34.3 хувь нь 16 настай, 24.1 хувь нь 17 настай, 1.4 хувь нь 18 настай сурагчид байна. (Зураг 1.)

Зураг 1. Сурагчдын нас, хүйс



Судалгаанд хамрагдсан сурагчдын анги, хүйсийг харьцуулж үзвэл эрэгтэй сурагчдын 15.1 хувь нь 10 дугаар анги, 13.9 хувь нь 11 дүгээр анги, 11.2 хувь нь 12 дугаар ангид суралцдаг бол эмэгтэй сурагчдын 22.4 хувь нь 10 дугаар анги, 20.5 хувь нь 11 дүгээр анги, 16.9 хувь нь 12 дугаар ангийн сурагчид байна. (Зураг 2.)

Зураг 2. Сурагчдын анги, хүйс




2.2. Эцэг, эх

Улсын хэмжээний 10-12 дугаар ангийн сурагчдын нийт 3947 эцэг эх судалгаанд хамрагдсан.


Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 83.1 хувь нь эмэгтэй, 16.9 хувь нь эрэгтэй байна. Эцэг эхчүүдийн 55.2 хувь нь 35-44 настай, 24.7 хувь нь 45-54 настай, 17 хувь нь 34 хүртэлх, 3.1 хувь нь 55-аас дээш настай байна. (Зураг 3.)

Зураг 3. Эцэг эхчүүдийн насны бүлэг




Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн боловсролын түвшнийг авч үзвэл 14.7 хувь нь магистр ба түүнээс дээш, 49.6 хувь нь дээд, 5.0 хувь нь тусгай дунд, 29.5 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь бүрэн бус дунд, 0.8 хувь нь бага боловсролтой бол 0.2 хувь нь боловсролгүй байна. (Зураг 4.)

Зураг 4. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин



Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 36.1 хувь нь төрийн байгууллагад, 23.5 хувь нь хувийн хэвшилд, 21.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол 12.7 хувь нь ажилгүй, 6.7 хувь бусад гэж хариулсан байна. (Зураг 5.)


Зураг 5. Эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



2.3. Багш, албан хаагч


Судалгаанд нийт 1312 багш, ажилтан хамрагдсанаас 19.3 хувь нь эрэгтэй, 80.7 хувь нь эмэгтэй байна. (Зураг 6.)

Зураг 6. Багш, албан хаагчдын насны бүлэг, хүйс



Багш, албан хаагчдын 28.0 хувь нь 1-5 жил, 23.9 хувь нь 6-10 жил, 17.2 хувь нь 11-15 жил, 14.4 хувь нь 16-20 жил, 16.5 хувь нь 21-ээс дээш жил боловсролын салбарт ажилласан байна. (Зураг 7.)

Зураг 7. Багш, албан хаагчдын ажилласан жилээр




ГУРАВ. СУДАЛГААНЫ ДҮН

3.1. Хүүхдийн шударга байдлын түвшин


Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 онд 3.97 оноотой гарч өмнөх буюу 2022 оноос 0.1 оноогоор өссөн дүнтэй байна. Судалгаанаас үзвэл хүүхдийн шударга байдлын үндсэн үзүүлэлтэд томоохон өөрчлөлт гараагүй байгаа ч эерэг тал руу тэмүүлэх хандлага ажиглагдаж байна. (Зураг 8.)

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор




Хүүхдийн шударга байдлын түвшний үзүүлэлтийг оршин суугаа нутаг дэвсгэрээр харьцуулан үзвэл Баян-Өлгий аймгийн хүүхдийн шударга байдал 4.19 оноотой гарч хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Харин Орхон аймгийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.79 буюу хамгийн бага дүнтэй гарчээ. Нийт судалгаанд хамрагдсан 21 аймгаас 14 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр дүнтэй гарсан бол 6 аймгийн үзүүлэлт улсын дунджаас доогуур дүнтэй гарчээ. Баян-Өлгий аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин 2022 онд улсын хэмжээнд хамгийн бага буюу 3.66 үзүүлэлттэй байсан бол 2023 онд 0.54 оноогоор өсөж улсын хэмжээнд тэргүүлсэн нь анхаарал татахуйц үзүүлэлт боллоо. (Зураг 9.)

Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 он, аймгаар



Хүүхдийн шударга байдлын түвшний үзүүлэлтийг Нийслэлийн дүүргүүдээр харьцуулан үзвэл Баянгол дүүрэг 4.16 оноотой буюу хамгийн өндөр дүнтэй гарчээ. Харин Баянзүрх дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн бага буюу 3.69 оноотой гарч, хоорондын 0.47 онооны зөрүүтэй байна. Баянгол, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх, Багахангай, Багануур дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр гарсан бол Сүхбаатар болон Баянзүрх дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна. (Зураг 10.)


Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 он, дүүргээр



Өмнөх онуудын судалгааны үр дүнгээс харахад жил бүр эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс өндөр гарч байсан бол 2023 оны хувьд ч мөн адил тус тохиолдол давтагдаж байна. Энэ оны судалгааны үр дүнгээр эмэгтэй хүүхдүүдийн шударга

байдлын түвшин 4.01 оноотой байгаа бол эрэгтэй хүүхдийнх 3.80 оноотой гарч 2022 оноос эрэгтэй хүүхдийн шударга байдал 0.02 оноогоор өссөн байна. (Зураг 11.)

Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



Төрийн өмчийн сургуулиудын хүүхдүүдийн шударга байдлын түвшин 2023 онд 3.79 оноотой гарсан бол хувийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.94 буюу 0.15 оноогоор дээгүүр үзүүлэлттэй байна. Өмнөх буюу 2022 онд төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшний үнэлгээ хувийн хэвшлийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин үнэлгээнээс их гарч байсан бол, энэ онд төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн үнэлгээ хувийн өмчийн сургуулийн хүүхдийн үнэлгээнээс бага гарсан байна. Судалгааны мэдээллээс үзвэл цаашид төрийн өмчийн сургуулиудын хүүхдүүдэд чиглэсэн шударга байдлыг төлөвшүүлэх хүрээний үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. (Зураг 12.)

Зураг 12. Хүүхдийн шударга байдлын түвшин, өмчийн хэлбэрээр



Хүүхдийн шударга байдлын түвшнийг тэдний насны онцлогт тохируулан хүүхэд зөв бурууг ялгаж буй эсэхийг илэрхийлэх, нийгмийн тогтсон хэм хэмжээ, зарчмыг хэрхэн сахиж буй байдлыг үнэлэх, бурууг үл тэвчиж буй чадварыг тогтооход чиглэсэн, дор дурдсан 12 асуултад хэрхэн хариулснаар үнэлэн шинжилж, дүгнэх замаар судлан тогтоосон болно. /Хавсралт 3./

Судалгааны мэдээллээс дэд үзүүлэлт бүрийн танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн түвшний үзүүлэлт дараах байдлаар харагдаж буй нь дор дурдсан дүгнэлтэд хүргэж байна.

Хүүхдийн ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт



Энэ үзүүлэлт нь хүүхдийн ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлэх бөгөөд судалгааны дүнгээс хүүхдийн ёс суртахууны талаарх танин мэдэхүй, нөлөөллийн түвшин зан үйлийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд чиглэсэн, ёс зүй, ёс суртахууны талаарх соён гэгээрүүлэх ажил шаардлагатай байгааг харуулж байна.

Хүүхдийн зөв шударга төлөвшилтийн дэд үзүүлэлт



Энэ үзүүлэлт хүүхэд зөв бурууг ялгаж буйг илэрхийлэх бөгөөд тус үзүүлэлтийн тухайд зан үйлийн түвшин танин мэдэхүйн болон нөлөөллийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд багаас нь зөв шударга байдлын дадал суулгах буюу томчуудын нөлөөлөл хэрэгтэй байгааг харуулж байна.

Хүүхдийн дүрэм, журам, хууль сахиу байдлын дэд үзүүлэлт



Энэ үзүүлэлт хүүхэд хэрхэн өөрийгөө хянаж, нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахиж буйг илэрхийлэх бөгөөд энэхүү үзүүлэлтийн нөлөөллийн болон зан үйлийн түвшин танин мэдэхүйн түвшнээс өндөр байгаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хүүхдэд таниулах шаардлага буйг илэрхийлж байна.

Хүүхдийн авлигыг үл тэвчих дэд үзүүлэлт




Энэ үзүүлэлт хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын чадварыг илэрхийлэх ба тус үзүүлэлтийн нөлөөллийн түвшин танин мэдэхүйн болон зан үйлийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд авлигын шинжтэй үйлдлийн талаар авах арга хэмжээний талаарх ойлголт дутмаг байгааг илэрхийлж байна.

3.2. Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл

Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл, түүний ач холбогдлыг тодорхойлох зорилгоор хүүхдийн шударга байдалд хөндлөнгөөс нөлөөлж болох хүчин зүйлийг тодорхойлох асуултад хариулт авах, улмаар тухайн хүчин зүйл нь хүүхдийн шударга байдлын түвшинд хэрхэн нөлөөлснийг аргачлалын дагуу 1-5 оноогоор үнэлэх замаар шинжлэн дүгнэв.


Судалгаагаар шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин 4.12 оноотой байгаа бол заримдаа ярилцдаг хүүхдийнх 3.88 оноотой, хэзээ ч ярилцдаггүй хүүхдийнх 3.59 оноогоор үнэлэгдсэн байна. Иймд эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэдтэйгээ шударга байх талаар ярилцдаг байх нь хүүхдийн төлөвшилд хамгийн чухал үзүүлдэг дүгнэж болохоор байна. (Зураг 13.)

Зураг 13. Шударга байх талаар гэрийнхэнтэйгээ ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх



Шударга хандсаныхаа төлөө магтуулж, сайшаагддаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.96 оноотой, шударга байсан ч үл ойшоогддог хүүхдийн шударга байдлын түвшин 3.84 оноогоор үнэлэгджээ. Хүүхдийг шударга үйлдэл хийх, аливаа зүйлд шударга хандахад нь магтан сайшаах, урамшуулах нь хүүхдэд багаас нь аливаа зүйлд шударга, зөв байхыг төлөвшүүлэх эерэг нөлөөтэй гэж судалгааны мэдээллээс дүгнэж байна. Иймд гэр бүл, сургууль болон бусад орчинд хүүхдийн шударга байдлыг урамшуулахад анхаарал хандуулах, шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй юм. (Зураг 14.)

Зураг 14. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх



Судалгаагаар шударга бус зүйл хийснийх нь төлөө гэр бүлийнхэн нь хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.97 оноотой, зэмлэж шийтгэдэг бол 3.89 оноотой, гэр бүлийнхэн нь сонирхдоггүй бол 3.52 оноогоор үнэлэгджээ. Зарим тохиолдолд эцэг эх, асран


хамгаалагчдын зүгээс хүүхдийг зэмлэж шийтгэхээс илүү учирлан хэлж, ойлгуулах нь илүү үр дүнтэй, эерэг нөлөөтэй байж болзошгүй байна. Иймд эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжил, шударга ёсны төлөвшилд зохих хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэдрэмжтэй хандах нь чухал юм. (Зураг 15.)

Зураг 15. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн гаргадаг хариу үйлдэл хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх



Судалгаагаар шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 3.95 оноотой гарсан бол, ярилцдаггүй хүүхдүүдийн үнэлгээ 3.79 оноотой гарсан байна. Үүнээс харахад хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчаас гадна үе тэнгийнхэний нөлөөлөл чухал байр суурийг эзэлж байна. (Зураг 16.)

Зураг 16. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 36 хувь нь интернэтээс, 23 хувь нь гэр бүлээсээ, 22 хувь нь сургуулийн орчноос, 7 хувь нь бусад эх сурвалжаас, 6 хувь нь тв, радиогоор, 2 хувь нь сонин, хэвлэлээс шударга ёсны талаарх мэдээлэл олж авдаг гэж хариулжээ. Харин гэр бүлээсээ шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн өндөр буюу 4.04 оноотой, сургуулийн орчноос мэдээлэл авдаг хүүхдийнх 4.02 оноотой, интернэт орчноос мэдээлэл авдаг хүүхдийнх 3.87 оноотой, тв, радиогоос мэдээлэл авдаг бол 3.83 оноотой, сонин хэвлэлээс 3.80 оноотой, бусад эх сурвалжаас мэдээлэл авдаг бол 3.77 оноотой харин найз нөхдөөсөө мэдээлэл авдаг бол 3.76 оноотой гарчээ. (Зураг 17, Зураг 18.)

Дээрх дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны хандлага, төлөвшилд гэр бүл, сургууль, интернэтийн орчин эергээр нөлөөлж байгаа бөгөөд хүүхдийн хамгийн олон цагийг өнгөрүүлдэг орчин, хүмүүс тэдний шударга ёс, байдлын төлөвшилд нөлөөлөх хүчин зүйл болдог нь тодорхой харагдаж байна. Иймд дээр дурдсанчлан, насанд хүрэгсэд буюу томчууд, сургуулийн багш, албан хаагчдад зориулсан, хүүхдэд шударга ёс төлөвшүүлэхэд чиглэсэн тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Зураг 17. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, хувиар




Зураг 18. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, түвшинээр



3.3. Эцэг, эхчүүдийн судалгааны дүн

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг эсэхийг хүйсээр авч үзэхэд ээж нарын 50.4 хувь нь байнга, 45.1 хувь нь заримдаа ярилцдаг гэсэн бол 0.9 хувь нь огт ярилцдаггүй байна. Харин аав нарын 47.2 хувь нь байнга 50.4 хувь нь заримдаа ярилцдаг бол 2.4 хувь нь хүүхэдтэйгээ шударга байдлын талаар огт ярилцдаггүй байна. Судалгаанаас харахад хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг эцэг эхчүүдийн тоо өмнөх онуудаас ихэссэн нь сайн үзүүлэлт юм. Мөн түүнчлэн гэр бүл нь хүүхдийн нийгэмшлийн анхдагч орчин болохын сацуу гэр бүлийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл нь хүүхэдэд чухал нөлөөтэй байдаг эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ зөв буруу, сайн муу, шударга, шударга бусын талаар нээлттэй ярилцаж, ойлгуулж байх хэрэгтэй.


Зураг 19. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг эсэх




3.4 Багш, албан хаагчдын судалгааны дүн

Судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 95.2 хувь нь сургуулийн албан хаагчид сурагчдад зөв шударга хүн болж төлөвшихөд үлгэр дуурайл болдог гэж үзсэн бол багш, албан хаагчдын 4.8 хувь нь сургуулийн албан хаагчид хүүхдийн төлөвшилд үлгэр дуурайл болдоггүй гэж үзсэн байна. Мөн 99.8% нь хүүхдийн шударга, зөв төлөвшилд гэр бүлийн орчин чухал гэж үзжээ.

Сургуулийн албан хаагчид сурагчдад зөв шударга хүн болж төлөвшихөд үлгэр дуурайл болдог



Зөв шударга хүн болж төлөвшихөд эцэг, эх, гэр бүлийн орчин чухал үүрэгтэй



Хүүхдийг шударга хүн болгож төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан багш, сургуулийн албан хаагчдаас хүүхдийг шударга хүн болгож төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих дараах арга хэмжээнүүдийг санал болгожээ.



“Анги удирдсан багшийн цагийг нэмж өгөх, ингэснээр сурагчидтайгаа тулж ажиллах боломжтой болно.”

“Бага ангиас нь буюу 1-5 дугаар ангийн сургалтын хөтөлбөрт зөв, эх оронч хүн болгон хүмүүжүүлэх, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх хичээлийн агуулгыг түлхүү тусгах шаардлагатай. Бага ангид дүн гэхээс илүү хүн болгож хүмүүжүүлэх талаас нь анхаарч суурийг нь сайн тавимаар байна.”



“Багш нар хичээлийн дүнг гаргах, сурагчдын амжилтыг дүгнэхдээ шударга ёсыг баримтлах, сургуулийн орчинд биеэ зөв авч явах, сурагчдаа ялгаж харьцахгүй байх зэргээр өөрснөө үлгэрлэх хэрэгтэй.”

“Зөвхөн багш гэлтгүй, хүүхдийн хүмүүжлийн асуудалд эцэг эхийг татан оролцуулах. Сургууль болон эцэг эх хамтран ажиллах.”



“Багшийн чанарыг сайжруулахын тулд багшийн цалинг нэмэх.”

“Гэр бүлд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол эцэг эхийн оролцоотой хийвэл эцэг эх ч төлөвшдөг сайн туршилага байна. Төрөөс хүүхдэд тэгш хандах хандлагаас л эхлэх байх.”



“Дээрээсээ эхлээд үлгэрлэ. Төр нь шударга бай. Улс орны төр барьж байгаа хүмүүс шударга үнэнч байдлаа ард иргэддээ харуулмаар байна.”

“Эцэг эхэд төлөвшил хүмүүжлийн талаарх ойлголтыг өгөөгүй цагт хүүхдээс төлөвшил нэхээд хэрэггүй. Иймд эцэг эхчүүдийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй.”



“Сурагчийн ёс зүйн дүрмийг баталж, сургууль бүр дагаж мөрддөг байх. Ингэвэл хүүхэд багаасаа дүрэм журамд захирагддаг, шударга, зөв суурь хүмүүжилтэй болно.”

ТАВ. ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдлын түвшин

- Хүүхдийн шударга байдлын түвшин 2023 онд 3.97 оноотой гарч өмнөх 2022 оноос 0.1 оноогоор өссөн, эерэг дүнтэй байна. Судалгааны мэдээллээс дүгнэвэл 2023 оны дүнд ихээхэн өөрчлөлт гараагүй ч хүүхдийн шударга байдлын үзүүлэлт тогтвортой бөгөөд эерэг тал руу тэмүүлсэн хандлагатай байна.
- Оршин суугаа нутаг дэвсгэрээр харьцуулан үзвэл судалгаанд хамрагдсан 21 аймгаас Баян-Өлгий аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин 4.19 оноотой гарч улсын хэмжээнд тэргүүлсэн байна. Өнгөрсөн 2022 онд улсын хэмжээнд хамгийн бага буюу 3.66 оноотой байсан бол 2023 онд 0.54 оноогоор өссөн нь анхаарал татахуйц үзүүлэлт боллоо.
- Судалгааг зохион байгуулсан цагаас эхлэн эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс өндөр гарч байсан. 2023 оны хувьд ч энэ үзүүлэлт давтагдан гарч эрэгтэй хүүхдийн шударга байдлын үзүүлэлт эмэгтэй хүүхдийн шударга байдлын үзүүлэлтээс доогуур дүнтэй гарсан байна. Иймд эрэгтэй эмэгтэй хүүхдийн хүйсийн онцлогт тохирсон шударга байдлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах нь үр дүнтэй байж болох юм.
- Өмчийн хэлбэрийн ялгаатай сургуулиудын хүүхдүүдийн шударга байдлын түвшний үзүүлэлт харилцан адилгүй дүгнэгдсэн байна. Өмнөх онд Төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин өндөр гарч байсан бол 2023 онд хувийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин өндөр гарсан байна. Иймд төрийн болон хувийн хэвлийн сургуулиудын сургалтын орчин, сургалтын үйл явцын ялгаатай байдлын судлан сайн туршлагыг авч шударга байдлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах нь үр дүнтэй байж болох юм.
- Хүүхдийн ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлэх асуулгын дүнгээс харахад хүүхдийн ёс суртахууны талаарх танин мэдэхүй, нөлөөллийн түвшин зан үйлийн түвшнээс доогуур байгаа тул хүүхдэд чиглэсэн, ёс зүй, ёс суртахууны талаарх асуудалд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна.
- Хүүхдийн шударга байдлын зан үйлийн түвшин танин мэдэхүйн болон нөлөөллийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд багаас нь зөв шударга байдлын дадал суулгах буюу томчуудын нөлөөлөл хэрэгтэй байгааг харуулж байна.
- Хүүхэд хэрхэн өөрийгөө хянаж, нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахиж буйг илэрхийлэх үзүүлэлтээр танин мэдэхүйн түвшин бага байгаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хүүхдэд таниулах, эрх зүйн талаар зохих ойлголт олгох шаардлагатайг илэрхийлж байна.
- Хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын чадварыг илэрхийлэх үзүүлэлтээр нөлөөллийн түвшин бага гарсан нь хүүхдэд авлигын шинжтэй үйлдэлд авах арга хэмжээний талаарх ойлголт дутмаг байгааг илэрхийлж байна.

Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл

- Шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин заримдаа ярилцдаг болон хэзээ ч ярилцдаггүй хүүхдийнхээс өндөр оноогоор үнэлэгдсэн байна. Иймд эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэдтэйгээ шударга байх талаар ярилцдаг байх нь чухал ач холбогдолтой юм. Иймд эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүдэд энэ талаарх ойлголт мэдээллийг

түгээж хүүхдэд зөв шударга байдлын дадал суулгах, төлөвшүүлэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

- Шударга хандсаныхаа төлөө магтуулж, сайшаагддаг хүүхдийн шударга байдлын түвшин өндөр байгаа нь хүүхдийг шударга үйлдэл хийх, аливаа зүйлд шударга хандахад магтан сайшаах, урамшуулах нь аливаа зүйлд шударга, зөв байхыг төлөвшүүлэх эерэг нөлөөтэй байна.
- Шударга бус зүйл хийснийх нь төлөө гэр бүлийнхэн нь хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин илүү өндөр оноотой байгаа бол, зэмлэж шийтгэдэг, гэр бүлийнхэн нь сонирхдоггүй хүүхдийн шударга байдлын оноо тааруу үнэлэгдсэн байна. Зарим тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийг зэмлэж шийтгэхээс илүү учирлан хэлж, ойлгуулах нь илүү үр дүнтэй, эерэг нөлөөтэй байж болзошгүй. Иймд эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжил, шударга ёсны төлөвшилд зохих хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэдрэмжтэй хандах нь чухал.
- Шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ, ярилцдаггүй хүүхдүүдийнхээс өндөр гарсан байна. Иймд, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчаас гадна үе тэнгийнхэний нөлөөлөл чухал байр суурийг эзэлж байна.

Хүүхдийг шударга хүн болгож төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ

- Судалгаанд хамрагдсан багш, албан хаагчид хүүхдийг шударга хүн болж төлөвшихөд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ гэх нээлттэй асуултад давтагдсан болон давтагдаагүй байдлаар олон янзын хариултууд ирүүлснээс хүүхдийн шударга байдлын төлөвшилд зөвхөн эцэг эх, багш, сургууль дангаар арга хэмжээ хэрэгжүүлэхээс илүү аль алиных нь хамтын оролцоо чухал гэх хариулт зонхилж байв. Мөн тус хүрээний мэдлэг, мэдээллийг шат шатны боловсролын хөтөлбөрийн агуулгад тусгах зэрэг саналыг дэвшүүлсэн. Үүнээс гадна “төр нь хүүхдийг ялгаварладаггүй байх, төрийн эрх баригчид шударга, үнэнч байдлаараа үлгэрлэх хэрэгтэй” гэх хариулт анхаарал татахуйц байлаа.

ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна:

- Эцэг, эх асран хамгаалагч, багш, ажилчид эрэгтэй болон эмэгтэй хүүхэдтэй хүйсийн ялгамжгүй, ижил тэгш харьцах. Аливаа асуудал тулгарахад шударга, зөв шийдвэрлэж, үйлдлээрээ үлгэрлэх. Зөвийг магтан урамшуулах, бурууг учирлан ойлгуулах.
- Хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсрол зэрэг шат шатны боловсролын хөтөлбөрт хүүхдийн насны онцлогт тохирсон ёс зүй болон эрх зүйн талаар зохих агуулгуудыг багтаах. Одоо хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрөөр хүүхдэд дээрх агуулгыг олгож чадаж байгаа эсэхийг үнэлэх.
- Хүүхдэд авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэгийг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургуулиуд сургуулийн орчинд дагаж мөрдөгдөх шинжтэй ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж, хүүхдэд үүрэг хариуцлага, зөв буруугийн ялгаа заагийг таниулах.
- Хүүхдийнхээ гэрээс гадуурх орчин дахь хүрээлэл, олон эх сурвалжаас олж авч буй мэдээ мэдээллийг цаг ямагт хянаж, зохицуулах нь боломжгүй тул зан үйл, харилцаа, хандлагад нь гарч буй өөрчлөлтийг анзаарч нээлттэй ярилцах, тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд туслах, тохиромжтой арга хэмжээг авах.
- Хүүхдийн шударга байдлын төлөвшилд эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилчдын хичээл зүтгэл голлох хүчин зүйл мөн хэдий ч нийгмийн гишүүн бүрийн оролцоо, эерэг хандлага ирээдүйн шударга иргэнийг бүтээхэд хувь нэмэртэй.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүүхдийн шударга байдлын түвшин, аймгаар, 2023 он

д/д	Аймаг	Хүүхдийн шударга байдлын түвшин						Зөрүү
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	
1	Архангай	3.79	3.88	3.99	4.05	4.00	3.90	↓-0.09
2	Баян-Өлгий	3.72	3.61	3.80	3.51	3.66	4.19	↑0.54
3	Баянхонгор	3.99	3.95	4.04	4.10	4.05	3.86	↓-0.19
4	Булган	3.98	3.88	3.92	4.00	4.00	4.00	↔0.00
5	Говь-Алтай	4.39	4.04	3.89	4.08	4.01	4.09	↔0.07
6	Говьсүмбэр	3.90	3.88	4.04	4.09	3.87	3.98	↔0.11
7	Дархан-Уул	4.11	3.93	4.03	4.04	3.96	3.88	↓-0.08
8	Дорноговь	4.14	3.95	4.08	4.03	3.89	4.00	↔0.12
9	Дорнод	3.96	3.93	4.02	4.10	4.03	4.11	↔0.08
10	Дундговь	4.19	3.93	4.07	4.13	4.14	4.18	↔0.04
11	Завхан	4.21	3.97	3.97	4.09	4.01	3.97	↔-0.04
12	Орхон	3.40	3.83	4.06	4.02	3.97	3.79	↓-0.19
13	Өвөрхангай	4.06	3.91	4.05	4.01	4.06	4.03	↔-0.02
14	Өмнөговь	3.39	4.03	4.03	4.17	4.01	4.06	↔0.06
15	Сүхбаатар	3.92	3.90	4.08	4.10	4.00	4.00	↔0.00
16	Сэлэнгэ	4.13	3.91	4.01	4.08	3.90	3.95	↔0.05
17	Төв	4.11	3.97	3.95	4.14	3.99	3.98	↔-0.01
18	Увс	4.11	3.98	4.09	4.17	4.05	4.06	↔0.01
19	Ховд	3.97	3.94	3.98	4.03	3.96	3.99	↔0.03
20	Хөвсгөл	4.01	3.99	4.07	4.07	4.04	4.01	↔-0.03
21	Хэнтий	3.89	3.94	3.95	4.05	3.98	3.89	↓-0.09

Хавсралт 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, дүүргээр, 2023 он

д/д	Дүүрэг	Хүүхдийн шударга байдлын түвшин						
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Зөрүү
1	Баянзүрх	4.04	3.88	4.01	4.11	3.87	3.81	👉-0.06
2	Баянгол	3.96	3.83	4.12	4.09	3.93	3.90	👉-0.03
3	Багануур	3.88	3.82	4.08	4.11	4.14	4.02	👇-0.12
4	Баганхангай	4.00	3.69	3.71	4.26	3.82	4.16	👆0.34
5	Налайх	3.04	3.86	4.12	4.06	4.01	4.00	👉-0.01
6	Сүхбаатар	3.60	4.08	4.13	4.06	3.87	3.69	👇-0.18
7	Хан-Уул	3.92	4.06	4.00	4.05	3.98	3.79	👇-0.19
8	Чингэлтэй	3.67	3.85	4.13	4.05	3.78	3.85	👉0.07
9	Сонгинохайрхан	3.87	3.83	3.97	4.06	3.90	4.08	👉0.18

Хавсралт 3. Хүүхдийн шударга байдлын түвшин дэд үзүүлэлтээр 2021, 2022, 2023 он

ҮЗҮҮЛЭЛТ		ҮНЭЛГЭЭ		
		2021	2022	2023
А. ХҮҮХДИЙН ЁС ЗҮЙ, ЁС СУРТАХУУНЫ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ				
Танин мэдэхүйн	БУСДЫН БҮТЭЭЛИЙГ АШИГЛАХДАА ЭХ СУРВАЛЖИЙГ ИШЛЭХ АЛБАГҮЙ	3.79	3.64	3.59
Нөлөөллийн	БАЯН БАЙХ НЬ ШУДАРГА БАЙХААС ИЛҮҮ ЧУХАЛ	4.34	4.30	4.25
Зан үйлийн	УРТ ДАРААЛАЛД ЗОГССОНООС УРДУУР НЬ ДАЙРЧ, КИНОНДОО ХУРДАН ОРНО	4.55	4.44	4.49
Б. ХҮҮХДИЙН ЗӨВ ШУДАРГА ТӨЛӨВШИЛТИЙН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ				
Танин мэдэхүйн	АНГИЙН ДАРГА БОЛОХЫН ТУЛД АНГИЙНХАНДАА БЭЛЭГ ӨГӨХ НЬ БАЙЖ БОЛОХ ЗҮЙЛ	4.59	4.50	4.51
Нөлөөллийн	БАГШДАА БЭЛЭГ ӨГӨХ НЬ ДҮНГЭЭ АХИУЛАХ САЙН АРГА	4.56	4.52	4.53
Зан үйлийн	ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН, АВЛИГА, ХЭЭЛ ХАХУУЛЬ АВСАН ХЭН НЭГНИЙГ ЗОХИХ БАЙГУУЛЛАГАД МЭДЭГДЭНЭ	4.11	3.97	4.03
В. ХҮҮХДИЙН ДҮРЭМ, ЖУРАМ, ХУУЛЬ САХИХ БАЙДЛЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ				
Танин мэдэхүйн	ДОТНЫН НАЙЗ НЬ ШАЛГАЛТ ӨГӨХДӨӨ БУСДААС ХУУЛЖ БАЙВАЛ “ЯАХ ВЭ ДЭЭ” ГЭЖ БОДНО	3.18	3.10	3.17
Нөлөөллийн	ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСНИЙХЭЭ ТӨЛӨӨ ШАН ХАРАМЖ АВЧ БОЛНО	4.04	3.90	3.83
Зан үйлийн	ЗАМЫН ЦАГДАА-ЗОХИЦУУЛАГЧ БАЙХГҮЙ БОЛ БИ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ ЗӨРЧИЖ МАГАДГҮЙ	4.07	3.94	3.91
Г. ХҮҮХДИЙН АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ БАЙДЛЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ				
Танин мэдэхүйн	ТОМ ХҮМҮҮСИЙН ҮЙЛДЭЛ ХУУЛЬ БУС БАЙСАН Ч ӨӨРТ НЬ АШИГТАЙ БОЛ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРНӨ	4.13	4.04	4.07
Нөлөөллийн	ШАЛГАЛТАА БУСДААС ХУУЛЖ БАЙГАА ХҮН НЬ МИНИЙ САЙН НАЙЗ БАЙСАН Ч ӨӨРИЙН ИТГЭДЭГ БАГШ, ЭЦЭГ, ЭХ, ХЭН НЭГЭНД МЭДЭГДЭНЭ	3.04	2.92	3.02
Зан үйлийн	МАНАЙ ГЭР БҮЛ БАЯЖИЖ Л БАЙВАЛ МИНИЙ ААВ, ЭЭЖ ЭРХ МЭДЛЭЭ АШИГЛАХ, ХУУЛЬ ЗӨРЧИХ НЬ НАДАД ХАМААГҮЙ	4.34	4.28	4.29
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН		4.06	3.96	3.97